**IAF Mandatory Document**

**ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг**

# МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

# WITNESSING ACTIVITIES FOR THE ACCREDITATION OF MANAGEMENT SYSTEMS CERTIFICATION BODIES

## Хэвлэл 2, Хувилбар 2

## (IAF MD 17:2023)

Хэвлэсэн огноо: 14.06.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 07.05.2020

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:
1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ

The IAF MLA is structured in five levels: Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

гэж нэрлэдэг. 4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.

- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

Хэвлэл 2, Хувилбар 2
Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо
Баталсан: ОУИФ-ын гишүүд
Огноо: 17.12.2018
Хэвлэсэн огноо: 14.06.2023
Хэрэгжиж эхлэх огноо: 07.05.2020
Холбоо барих: Элва Нилсен
ОУИФ Нарийн бичгийн дарга
Утас: +1 613 454-8159
И-мейл: secretary@iaf.nu

Issue 2, Version 2
Prepared by: IAF Technical Committee
Approved by: IAF Members
Date: 17 December 2018
Issue Date: 14 June 2023
Application Date: 07 May 2020
Name for Enquiries: Elva Nilsen
IAF Corporate Secretary
Contact Phone: +1 (613) 454 8159
Email: secretary@iaf.nu

**АГУУЛГА**

0. УДИРТГАЛ

1. ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Гэрчлэх ажиллагаа
1.2 Баримт бичгийн үзлэг
1.3 Итгэмжлэлийн хүрээ

2. ЕРӨНХИЙ БОДЛОГО

2.1 Зорилт
2.2 Ерөнхий бодлого
2.3 Итгэмжлэлийн хүрээг хамарсан гэрчлэх үнэлгээ хийх ерөнхий заавар

2.4 Гэрчлэх үнэлгээ явуулах ерөнхий заавар

3. ЖУРАМ

4. ХҮРЭЭГ ТҮҮВЭРЛЭХ ОНЦЛОГ ХАНДЛАГА

4.1 Хэрхэн хүснэгтийг унших талаар - Тайлбарууд
4.2 ЧМТ, БОМТ, ХЭМАБ-т хэрэглэх ерөнхий дүрэм

5. ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО (ISO 9001)

6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО (ISO 14001)

7. ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО (ISO 45001)

**TABLE OF CONTENTS**

0. INTRODUCTION

1. DEFINITIONS

1.1 Witnessing
1.2 File review
1.3 Scope of Accreditation

2. GENERAL POLICIES

2.1 Objectives
2.2 General Policies
2.3 General Instructions for Using Witnessing to Cover the Scope of Accreditation
2.4 General Instructions for Carrying Out a Witnessing

3. PROCEDURES

4. SPECIFIC APPROACH FOR SAMPLING OF SCOPES

4.1 How to Read the Tables - Explanations

4.2 General Rules Applicable to QMS, EMS, and OH&SMS Schemes

5. QUALITY MANAGEMENT SYSTEMS (ISO 9001)

6. ENVIRONMENTAL MANAGEMENT SYSTEMS (ISO 14001)

7. OCCUPATIONAL HEALTH & SAFETY MANAGEMENT SYSTEMS (ISO 45001)

## ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томьёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулссан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томьёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

## INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

## МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Энэхүү баримт бичиг нь ISO/IEC 17011 "Тохирлын үнэлгээ – Тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх итгэмжлэлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага" стандартыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай.*

*Энэхүү баримт бичгийг хүчинтэй стандарт (ISO/TS 22003, IAF MD 8, ISO 27006), ОУИФ-ын бусад баримт бичиг, СЭ (схем эзэмшигч) эсвэл зохицуулагч байгууллагаас гаргасан тодорхойлолт, хууль тогтоомжтой зөрчилдөхөөс бусад тохиолдолд МТ (менежментийн тогтолцоо)-ны ББ (баталгаажуулалтын байгууллага)-ыг итгэмжлэхэд хэрэглэх ба ОУИФ-н ОТХХЗХ-ийн дараах бүх МТ-ын тогтолцоонд ашиглана.*

*5, 6 болон 7-р хэсэгт ЧМТ-ны ББ, БОМТ-ны ББ болон ХЭМАБМТ-ны ББ-ыг итгэмжлэлийн тухай нарийвчлан заасан болно.*

### 0. УДИРТГАЛ

0.1. ISO/IEC 17011:2017 стандартын 7.4.4, 7.4.5-д заасны дагуу Итгэмжлэлийн байгууллага (ИБ) нь итгэмжлэлийн хүрээнд хамаарах бүхий л үйл ажиллагааг хаана ч гүйцэтгэх боломжтой тохирлын үнэлгээний байгууллагын чадамжийг үнэлэх баримтжуулсан журамтай байх шаардлагатай. Эдгээр үйл ажиллагаа нь итгэмжлэлийн холбогдох шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхэд итгэх хангалттай газар дээрх үнэлгээ болон бусад үнэлгээний аргуудыг хослуулан ашиглах замаар хийгддэг. Үнэлгээнд тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн хүрээнд хамаарах үйл ажиллагааг гүйцэтгэх чадамжийг

## WITNESSING ACTIVITIES FOR THE ACCREDITATION OF MANAGEMENT SYSTEMS CERTIFICATION BODIES

*This document is mandatory for the consistent application of the relevant clauses of ISO/IEC 17011:2017 Conformity assessment - General requirements for accreditation bodies accrediting conformity assessment bodies.*

*This document applies to the accreditation of MS (Management Systems) CBs (Certification Bodies) and shall be used for all MS under the IAF MLA, except for those provisions that conflict with what is established in applicable standards (e.g. ISO/TS 22003, IAF MD 8, ISO 27006), other IAF documents, specifications set by SOs (Scheme Owners) or regulators, and legislation.*

*Sections 5, 6, and 7 are specific to the accreditation of QMS CBs, EMS CBs, and OH&SMS CBs respectively.*

### 0. INTRODUCTION

0.1. According to ISO/IEC 17011:2017 clause 7.4.4 and clause 7.4.5, Accreditation Bodies (ABs) are also required to establish documented procedures to assess the competence of conformity assessment body to perform all activities in its scope of accreditation irrespective of where these activities are performed, through the use of a combination of on-site assessments and other assessment techniques sufficient to provide confidence in the conformity with the relevant accreditation criteria. The assessment shall cover a sample of locations and personnel to determine the competence of the conformity assessment body to perform the activities covered by its scope of accreditation. For further details please refer to

тодорхойлох байршил, ажилтны түүврийг хамруулна. Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/IEC 17011:2017 стандартын 7.9.2, 7.9.3 дахь заалтаас үзнэ үү.

clause 7.9.2 and clause 7.9.3 of ISO/IEC 17011:2017.

0.2 ISO/IEC 17011 стандартын эдгээр шаардлагуудад (болон холбогдох нөхцөлд ОУИФ-ын боловсруулсан бусад норматив баримт бичгүүд, эрх зүйн шаардлагад) нийцэхийн тулд ИБ бичиг баримтанд үзлэг хийх бөгөөд МТ-ны ББ-д гэрчлэх ажиллагаа гүйцэтгэнэ, тухайлбал баталгаажуулалтын үйл явцын аудитад (цаашид аудит гэх).

0.2. In order to comply with these requirements of ISO/IEC 17011 (and other normative documents like application documents developed by IAF and legal requirements where relevant), ABs perform file review and witnessing of MS CBs activities, namely audits in the certification process (hereafter referred to as audits).

0.3 Энэхүү баримт бичгийн зорилтот хэрэглэгчид нь МТ-ны ББ, ИБ болон ижил түвшний үнэлгээний мэргэжилтнүүд, хууль тогтоогчид, схем эзэмшигч (СЭ), үйл ажиллагааныхаа хүрээнд ОУИФ-ын ХХЗХ-ийн найдвартай байдалд түшиглэдэг бусад оролцогч талууд болно.

0.3. The intended audience for this document is MS CBs, ABs and their peer evaluators, regulators and scheme owners (SO), and other stakeholders that rely upon the credibility of the IAF MLA for the purpose of their activities.

## 1. ТОДОРХОЙЛОЛТ

Энэ баримт бичигт дараах нэр томъёог хэрэглэнэ. Үүнд:

### 1.1. Гэрчлэх

ТҮБ итгэмжлэлийн хүрээндээ тохирлын үнэлгээний үйл ажиллагааг гүйцэтгэж буйг ажиглах (ISO/IEC 17011:2017 стандартын 3.25-р заалт)

Гэрчлэх аудит бол баталгаажуулалтын байгууллагын аудитын багийн гүйцэтгэж буй аудитыг итгэмжлэлийн байгууллага саад учруулахгүй, нөлөөлөхгүйгээр ажиглах үйл ажиллагаа юм. Гэрчлэх ажиллагааны зорилгоос хамаарч нийт аудитыг эсвэл аудитын зөвхөн холбогдох хэсгийг ажиглана. Гэрчлэх ажиллагааг ББ-ын үйлчлүүлэгчийн байран дээр эсвэл зайнаас хийх аудитыг цахим байдлаар ажиглаж явуулна.

Тайлбар: ИБ энэхүү баримт бичгийн хүрээнээс гадуур ББ-удын явуулдаг бусад үйл ажиллагааг итгэмжлэлийн үйл явцад гэрчилж болно.

### 1.2. Баримт бичгийн үзлэг

ББ-ын холбогдох журмуудыг мөрдөж, хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлохын тулд ИБ тухайн баталгаажуулалтын бичиг баримтад хамаарах бүртгэл, баримт бичгийг үнэлж, шалгах ажиллагаа. Үүнийг холбогдох ББ-ын ажилтан ба/эсвэл аудиторын хамт ихэвчлэн ББ-ын ажлын байранд явуулдаг боловч зохимжтой, тохиролцсон нөхцөлд алсын зайнаас эсвэл өөр газарт (жишээ нь ББ-ын үйлчлүүлэгчийн ажлын байранд) гүйцэтгэж болно.

### 1.3. Итгэмжлэлийн хамрах хүрээ

ББ тодорхой байршилд итгэмжлэгдсэн баталгаажуулалт олгох тодорхой менежментийн тогтолцооны стандарт, тэдгээрийн холбогдох хэсэг, код, сектор, төрөл эсвэл техникийн салбар

## 1. DEFINITIONS

For the purposes of this document, the following definitions apply:

### 1.1. Witnessing

Observation of the CAB carrying out conformity assessment activities within its scope of accreditation (clause 3.25 of ISO/IEC 17011:2017).

Witnessing of an audit is an activity performed by an AB whereby it observes, without interfering and influencing, an audit performed by a CB audit team. Depending upon the objectives of the witnessing, the complete audit may be observed or just relevant parts of the audit. The witnessing is done on-site at the CB client premises or observing remote auditing via electronic means.

Note: ABs may witness other activities conducted by CBs as part of their accreditation process, outside of the scope of this document.

### 1.2. File Review

Activity performed by an AB whereby it reviews and evaluates the records and documents pertaining to a given certification file, in order to determine whether the relevant CB procedures were followed and implemented. This is normally done at the CB premises, with the appropriate CB staff and/or auditors, although it may be performed remotely or elsewhere (e.g.: CB client premises) as appropriate and agreed.

### 1.3. Scope of Accreditation

Specific management system standards and their relevant parts, codes, sectors, categories or technical areas, according to which CBs grant an accredited certification in a specific location.

## 2. ЕРӨНХИЙ БОДЛОГО

### 2.1. Зорилго

2.1.1. ISO/IEC 17011:2017 стандартын § 7.4.4 ба § 7.4.5-т зааснаар гэрчлэх ажиллагааны зорилго нь итгэмжлэлийн хүрээнд МТББ-ын чадвар нийцтэй эсэхийг батлах явдал юм. Аудит хийх үйл явц болон аудит хийх ажилтнуудын холбогдох ур чадварт тавих шаардлагыг ISO/IEC 17021-ын цуврал стандартуудад тодорхойлсон.

2.1.2. ББ-ын үйлчлүүлэгчиддээ хийх аудитыг ИБ гэрчлэх нь дараах ач холбогдолтой:

i) ББ-ын баталгаажуулалтын хөтөлбөр ба журам (ялангуяа аудитын багийн ур чадварыг тогтоох, аудитын хугацааг тодорхойлох)-ыг үр дүнтэй хэрэгжүүлж буй эсэхийг газар дээр нь батлах ба ББ үйлчлүүлэгчдэд зориулан хамрах хүрээг зөв тогтоох,
ii) Ажиглаж байхдаа ББ-ын аудиторуудын дараах байдлыг үнэлнэ:
   a. ББ-ын журамд нийцэх;
   b. дараах шаардлагуудад нийцэж буйг тогтоох:
      - баталгаажуулалтын шаардлага;
      - ISO/IEC 17021-ийн хамаарах заалтууд;
      - IAF-ын холбогдох баримт бичгүүд; болон
      - хэрэгжүүлэх аливаа холбогдох секторын тодорхой шаардлагууд.
iii) итгэмжлэлийн хүрээнд ББ-ын чадварыг төлөөлөх түүвэр авах.

2.1.3. Энэхүү баримт бичиг нь ИБ-аас ББ шаардлага хангасан төлөвлөх болон аудит гүйцэтгэх ажилтнуудтай эсэхийг тодорхойлох, итгэмжлэлийн хүрээнд баталгаажуулалтын аудит гүйцэтгэх чадвартай эсэхийг үнэлэх боломжийг олгоно.

## 2. GENERAL POLICIES

### 2.1. Objectives

2.1.1. The objective of witnessing, in conformity with §7.4.4 and §7.4.5 of ISO/IEC 17011:2017, is to provide assurance of the competence of the MS CB across the scope of accreditation. The competence requirements related to auditing and auditing personnel are specified in ISO/IEC 17021 series.

2.1.2. The witnessing of CB's audits on their clients by ABs is valuable for:

i) verifying, on site, the effective implementation of the CB's certification programmes and procedures (and especially with regard to their assignment of competent audit teams and determination of audit time) and determine the correct assignment of scope by the CB for the client,
ii) observing the CB's auditors to evaluate if they:
   a. conform with the CB's procedures;
   b. adequately address the requirements of:
      - certification requirements;
      - applicable points of ISO/IEC 17021-1;
      - relevant IAF documents; and
      - any relevant sector specific requirements, as applicable.
iii) obtaining a representative sample of the competence of the CB across the accreditation scope.

2.1.3. This document will enable an AB to determine whether the CB has competent scheduling/planning and auditing personnel, and to assess the CB's competence to perform certification audits under accreditation.

2.1.4. Гэрчлэх ажиллагааг өөр бусад шалтгаанаар хийж болно. Үүнд: Гомдол хүлээн авах, зарга, маргаан, зах зээл эсвэл захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ИБ-ын журам ба/эсвэл бодлогын дагуу гэрчлэх үнэлгээг хийж болно.

2.1.4. Witnessing can also be initiated for other reasons, according to the AB's procedures and/or policies e.g. upon the receipt of complaints, claims, disputes, market or regulator feedback.

**2.2. Ерөнхий бодлого**

2.2.1. ИБ олон төрлийн механизм ашиглан өргөдөл гаргагч болон итгэмжлэгдсэн ББ бүрийн хүрээ (1.3-ыг үзнэ үү)-г хамарсан бодлоготой байна. Эдгээр механизмд дараах зүйлс багтана. Үүнд:

i) оффис үнэлгээний ажиллагаа;
ii) гэрчлэх ажиллагаа; болон
iii) ИБ-аас тодорхойлсон хэрэгцээний дагуу бусад үнэлгээний ажиллагаа

Энэхүү бодлого нь ИБ-ууд итгэмжлэлийн хамрах хүрээг төлөөлөхүйц тохирлын үнэлгээний үйл ажиллагааны түүврийг авч, гүйцэтгэлийг үнэлдэг байх ёстой. (ISO/IEC 17011:2017 стандартын 7.4.5-ыг үзнэ үү).

2.2.2. ИБ нь ББ ба түүний үйлчлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээнд ИБ-ийн гэрчлэх ажиллагааны шаардлагыг тусгасан эсэхийг шалгах ба ИБ-аар гэрчлэх үнэлгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэл нь ББ болон ИБ-р хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой. Хэрэв шалтгаан, үндэслэл хүлээн зөвшөөрөгдөхүйц биш бол итгэмжлэгдсэн баталгаажуулалтыг нь цуцалж болно.

**2.2. General Policies**

2.2.1. ABs shall have a policy to cover the scope (see 1.3) for each applicant and accredited CB through the use of the various mechanisms that are available, including:

i) office assessment activities;
ii) witnessing activities; and
iii) other assessment activities, as defined by the AB according to the needs identified.

The policy shall ensure that the ABs assess the performance of a sample of the conformity assessment activities representative of the scope of accreditation (see 7.4.5 of ISO/IEC 17011:2017).

2.2.2. ABs shall ensure that the requirement for witnessing by the AB is included in the contract agreements between CBs and their clients and confirm that refusal to accept a witness assessment by the AB, must be justified and accepted by the CB and the AB, and could result in withdrawal of accredited certification where reasons are not accepted.

**2.3. Итгэмжлэлийн хүрээг хамарсан гэрчлэх үнэлгээ/ажиллагаа хийх ерөнхий заавар**

2.3.1 ИБ нь итгэмжлэлийн мөчлөг бүрт итгэмжлэгдсэн эсвэл өргөдөл гаргагч ББ-ын хамрах хүрээг багтаасан үнэлгээний хөтөлбөртэй байна. Шаардлагатай бол хөтөлбөрийг тодорхой хугацааны дараа хянаж, шинэчлэнэ.

**2.3. General Instructions for Using Witnessing to Cover the Scope of Accreditation**

2.3.1. ABs shall have an assessment programme covering the scope of each applicant or accredited CB for each accreditation cycle. The programme must be periodically reviewed and updated, as needed.

2.3.2 Хөтөлбөр нь ББ-ын үйл ажиллагааны хэмжээ, тэдгээрийн эгзэгтэй байдал болон орон нутгийн ИБ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэх бөгөөд хил дамнасан баталгаажуулалтын үйл ажиллагааг үнэлэх хэрэгцээнд ач холбогдол өгөх ёстой. Хэрвээ гэрчлэх ажиллагаа шаардлагатай бол ИБ нь ХХЗХ-ийн дүрэм, тогтоомжийн дагуу орон нутгийн ИБ-тай хамтран ажиллах арга замтай байх ёстой.

2.3.2. The programme shall consider the need to assess any cross-frontier certification activities, based on the size of the CB operations, their criticality, and feedback from the local AB. If witnessing is needed, the AB shall have a process for cooperation with the local AB, according to MLA rules and regulations.

2.3.3. Гэрчлэх аудитын тоо, төрлийг шийдэхдээ ИБ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

i) ББ-ын нийт гүйцэтгэл;
ii) Баталгаажсан байгууллагын МТ-ны хүлээгдэж буй үр дүнд хүрэх чадварт нөлөөлдөг үйл явцын нарийн төвөгтэй байдал, хууль тогтоомж зэрэг хүчин зүйлс;
iii) Баталгаажсан байгууллагын байгууллагын талаарх гомдол г.м сонирхогч талуудын ирүүлсэн мэдээлэл;
iv) ББ-ын дотоод аудитын үр дүн;
v) схем эзэмшигчийн шаардлага г.м;
vi) ББ-ын ажлын загвар дахь өөрчлөлт-тодорхой бүс, техникийн салбар дахь ажлын өсөлт;
vii) ББ-ын итгэмжлэлийн хүрээн дэх үйлчлүүлэгчдийн тоо;
viii) ББ-ын аудиторын үнэлгээ, хүлээн зөвшөөрөх үйл явцын найдвартай байдал; болон
ix) өмнө хийгдсэн эсвэл бусад оффис эсвэл гэрчлэх үнэлгээний үр дүн гэх мэт

2.3.3. When deciding how many and which audits are to be witnessed, the AB shall take into account factors such as:

i) the CB's overall performance;
ii) factors such as process complexity or legislation etc. which influence the ability of the certified organisation to demonstrate its ability to meet the intended outcomes of the MS;
iii) feedback from interested parties including complaints about certified organizations;
iv) the results of the CB's internal audits;
v) scheme owner requirements, etc.;
vi) changes in CB work patterns – growth of work within a specific region or technical area;
vii) number of clients within the CB’s scope of accreditation;
viii) confidence in the CB’s auditor evaluation and approval process; and
ix) previous or other office or witnessing assessment results, etc

Гэрчлэх үйл ажиллагааг сонгохдоо дараах нэмэлт хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

i) олгосон гэрчилгээний тоо;
ii) аудиторын тоо;
iii) төрөл бүрийн аудиторууд;
iv) аудиторууд нь дотоод эсвэл гадаад эх үүсвэрээс эсэх;

The following additional factors may be taken into account to select witnessing activities:

i) number of certificates issued;
ii) number of auditors;
iii) different auditors;
iv) whether auditors are internal staff or external resource;
v) different audits, initial audit (stage 1/stage 2), surveillance and recertification;

v) төрөл бүрийн аудитууд, анхны аудит (1-р шат/2-р шат), магадлах шалгалт ба давтан баталгаажуулалт;
vi) нарийн төвөгтэй үйлчлүүлэгч, хамтарсан ба/эсвэлнэгдмэл аудит, олон салбарт хийх аудит;
vii) баталгаажуулалтын үйл явцад аудит гүйцэтгэх улс орнууд;
viii) сүүлд хийгдсэн гэрчлэх ажиллагааны үр дүн;
ix) гомдол, хэрэглэгчийн судалгаа;
x) сонирхогч талууд ба захиргааны байгууллагын шаардлага;
xi) өмнө нь үнэлсэн техникийн бүлгүүд;
xii) ББ-ын итгэмжлэлийн бусад төрлүүдээс хуримтлуулсан туршлага;
xiii) ББ өөрийн үйл ажиллагааг өмнө нь удирдаж байсан чадвартай эсэх;
xiv) ББ өөрийн чухал үйл ажиллагааг хянах хяналтын түвшин;
xv) тодорхой схемийн шаардлага;
xvi) үйлчлүүлэгчтэй хийсэн үндэсний хэлэлцээр.

vi) complex clients, combined and/or integrated audits, multi-site audits;
vii) countries where audits in the certification process are performed;
viii) result of previous witnessing activities;
ix) complaints, customer surveys;
x) interested parties and regulators requests;
xi) the technical clusters already assessed;
xii) experience from other types of accreditation of the CB;
xiii) previous history of the CB’s ability to manage its operations;
xiv) level of controls exercised by a CB over its critical activities;
xv) specific scheme requirements; and
xvi) national agreements with clients.

### 2.4. Гэрчлэх үнэлгээ/ажиллагаа явуулах ерөнхий заавар

2.4.1. ИБ хүсэлт гаргасан тохиолдолд Баталгаажуулалтын байгууллага баталсан, төлөвлөгөөт аудитынхаа бүрэн, шинэчлэсэн хөтөлбөрийг Итгэмжлэлийн байгууллагад хүлээлгэн өгөх ёстой (өдөр, байршил, аудитын баг, бүрэлдэхүүн, аудитын төрөл ба хамрах хүрээ зэрэг). Ингэснээр ИБ итгэмжлэлийн хүрээний дагуу хөтөлбөрөө хуваарилж, шинэчлэх боломжтой болно.

2.4.2. ИБ нь тухайн гэрчлэх үнэлгээнд хамрагдахаас татгалзсан (үүнд ББ-ын үйлчлүүлэгчээс ирсэн) татгалзлыг хариуцах бодлого баримтална, үүнд татгалзлыг зохих ёсоор үндэслэлгүй, ИБ хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ББ-д шийтгэл ногдуулах (жишээ нь: аюулгүй байдал гэх мэт) байх ёстой. зөвшөөрөл) ба/эсвэл өргөдөл гаргагч эсвэл магадлан итгэмжлэгдсэн хамрах хүрээг алдагдуулж байна. Хэрэв ББ-ын үйлчлүүлэгч

### 2.4. General Instructions for Carrying Out a Witnessing

2.4.1. When requested, the CB shall promptly provide to the AB the complete and updated schedule of confirmed and planned audits (dates, location, audit team composition, audit type and scope, etc.), in order to allow the AB to schedule or update the program for the coverage of the scope of accreditation.

2.4.2. ABs shall have a policy to deal with refusals by a CB (including those originating from the CB client) for a given witnessing, including the imposition of sanctions on the CB when the refusal is not duly justified and accepted by the AB (e.g.: security clearance) and/or compromises the coverage of the applicant or accredited scope. If the CB client refuses the AB witnessing, in order to avoid

ИБ-г гэрчлэхээс татгалзвал шийтгэлээс зайлсхийхийн тулд ББ нь одоо байгаа итгэмжлэгдсэн гэрчилгээг эргүүлэн татна.

2.4.3. Хэрэв ББ-д хориг арга хэмжээ авсны дүнд гэрчилгээ нь цуцлагдвал, үүний нөлөөнд автаж болзошгүй, нэр, хаяг нь тодорхой байгаа ИБ ба бүх схем эзэмшигчдэд мэдэгдэнэ. Хэрэв тухайн байгууллага аудитаа гэрчлүүлэхээс зайлхийх зорилгоор өөр ББ-д гэрчилгээ шилжүүлэх эсвэл ББ өөр ИБ-с ижил гэрчилгээ авахаар завдсан бол итгэмжлэгдсэн гэрчилгээг олгохгүй.

2.4.4. Гэрчлэх үнэлгээнээс өмнө ИБ нь ББ-ын байгууллагын аудитын төлөвлөгөө, хэрэв шаардлагатай бол сүүлд хийгдсэн аудитын тайлан, аудитын багийн ур чадварын бүртгэл ба аудитын хугацааг тооцоолсон үндэслэлийг шалгана.

2.4.5. Гэрчлэх ажиллагаа бүрт ИБ байгууллага холбогдох итгэмжлэлийн хүрээнд ажиллах ур чадвартай үнэлгээний багийг томилно. ИБ нь Итгэмжлэлийн байгууллагын үнэлгээний багийн бүрэлдэхүүний талаар Баталгаажуулалтын байгууллагад урьдчилж мэдэгдэнэ. Баталгаажуулалтын байгууллага болон түүний үйлчлүүлэгч нь Итгэмжлэлийн байгууллагын үнэлгээний мэргэжилтэн нь өрсөлдөгч байгууллагатай нь ойр дотно буюу шууд харилцаатай (шударга байдалд нөлөөлөх) эсвэл өмнө нь тухай үнэлгээний мэргэжилтэнтэй холбоотой гарсан, үндэслэлтэй гомдол зэрэгт үндэслэн татгалзаж болно.

2.4.6. ББ нь үйлчлүүлэгчиддээ мэдээлэх, гэрчлэх журмыг тайлбарлах, зөвшөөрлийг нь авах үүрэгтэй. Баталгаажуулалтын байгууллага гэрчлэх үнэлгээ дуустал аудитын баг, аудитын төлөвлөгөө эсвэл аудитын хугацааг өөрчилж болохгүй. Хэрэв ямар нэгэн өөрчлөлт оруулах бол Баталгаажуулалтын байгууллага

sanctions, the CB shall withdraw the existing accredited certificate.

2.4.3. If sanctions are imposed on a CB resulting in certificate withdrawal then other ABs and all scheme owners who may be impacted shall be notified, if their identity is known. An accredited certificate shall not be issued if, in order to avoid having its audit witnessed, the organization transfers the certificate to another CB or if the CB intends to reissue the same certificate under the coverage of another AB.

2.4.4. Pre-witness activities shall ensure that the AB has the CB's audit plan, previous audit reports if applicable, audit team competence records and the justification for calculation of the audit time.

2.4.5. For each witnessing, the AB shall appoint an assessment team, competent in the relevant scope of accreditation. The AB shall inform the CB in advance of the AB assessment team composition. The CB and/or its client can object to the nomination of a given AB assessor on the grounds of demonstrated close or direct relationships with competitors (threats to impartiality) or a previous valid complaint against an assessor, etc.

2.4.6. It is the duty of the CB to inform its client, to explain the witnessing procedure, and to get the client’s agreement. The CB is not expected to change its audit team, audit plan or audit duration due to the witnessing. If such changes do take place, the CB shall provide appropriate justification to the AB.

Итгэмжлэлийн байгууллагад зохих үндэслэлийг гаргаж өгнө.

2.4.7. Үнэлгээний туршид Итгэмжлэлийн байгууллагын үнэлгээний мэргэжилтний ажиллагаа нь Баталгаажуулалтын байгууллагын аудитын багийн гүйцэтгэж буй аудитад нөлөөлөхгүйгээр ажиглагч байдалтай байна. ББ-ын аудитын баг шалгалт шинжилгээ хийсэн үйлчлүүлэгчийн баримт бичгийг ИБ-ын үнэлгээний мэргэжилтэн үзэхийг хүсвэл даруй гаргаж өгнө.

2.4.7. During witnessing, the AB assessors' activities shall be those of an observer, without influencing the conduct of the audit by the CB's audit team. Access to the client's documentation reviewed by the CB's audit team shall be promptly provided to the AB's assessors upon request.

2.4.8. Аудитыг гэрчлэх явцад цуглуулсан аливаа мэдээллийг нууцлах ба ИБ-ын үнэлгээний мэргэжилтэн, ажилтнууд л үзэх ёстой.

2.4.8. Any information collected during the witnessing of an audit is confidential and shall be treated by the AB assessors and staff accordingly.

2.4.9. ИБ ББ-ын үйлчлүүлэгчээс шууд асуулт асуухыг зөвшөөрөхгүй, энэ нь аудитын үр дүнд нөлөөлж болно. ИБ-ын үнэлгээний мэргэжилтнүүд ББ-ыг аудит гүйцэтгэж байхад ямар нэгэн санал гаргахгүй. ИБ-ын үнэлгээний мэргэжилтнүүд аудитыг ажиглахдаа ББ-н үйлчлүүлэгчид аудитад нь хөндлөнгөөс оролцож байгаа мэт ойлголт төрүүлэхгүй харин эерэг ойлголт төрүүлбэл зохино.

2.4.9. The direct questioning of the CB’s client by the AB is not allowed, as this can affect the outcome of the audit. AB assessors shall not provide any opinions to the CB, while the audit is being conducted. The AB assessors shall not provide any opinions to the CBs client at any time. AB assessors should ensure that their presence and witnessing activity is not perceived as interference by the CB's client, and is instead viewed positively.

2.4.10. Ердийн нөхцөлд газар дээрх аудитад бүхэлд нь гэрчлэх үнэлгээ хийдэг боловч тухайн үйл ажиллагааны зорилгыг хэсэгчилсэн гэрчлэх үнэлгээгээр биелүүлэх боломжтой бол бүхэлд нь гэрчлэх шаардлагагүй.

2.4.10. Normally, the full on-site audit shall be witnessed, unless objectives for a particular activity can be satisfied with a partial witnessing.

2.4.11. Үнэлгээний аливаа дүгнэлт/үл тохирлыг агуулсан ББ-ын гүйцэтгэлтэй холбоотой санал хүсэлтийг гэрчлэх ажиллагаа дуусхад ББ-ын аудитын багт өгөх ёстой. Санал хүсэлтэд ИБ-ын тайлагнах үйл явц, ББ-ын харилцах үйл явц ба ИБ-ын шийдвэр гаргах үйл явц багтана. Энэхүү санал хүсэлтийг боломжтой нөхцөлд ББ-ын удирдлагад мөн гаргаж өгвөл зохино. Энэ нь

2.4.11. Feedback on the CB’s performance, including any assessment findings/non-conformities, shall be given to the CB’s audit team when the witnessing is completed. The feedback should include outlining the AB’s reporting process, the CB response / reaction process and the AB decision-making process. Where possible this feedback should be provided to the CB’s management as well. This

аудитын дараа зөвхөн ББ-ын үйлчлүүлэгч байхгүй үед хийгдвэл зохино.

2.4.12. Гэрчлэх ажиллагааны хамрах хүрээ, зорилготой холбоотой нөхцөлд ИБ-ын үнэлгээний мэргэжилтнүүд ББ-ын аудитын тайланг (болон бусад шаардлагатай нэмэлт мэдээллийг) авч, шалгана хийнэ.

2.4.13. ББ-ын үйлчлүүлэгч аудитын баг, ИБ-ын үнэлгээний мэргэжилтнүүдэд хэрэглэгдэх бүх аюулгүй байдлын шаардлагуудыг урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. ИБ-ын үнэлгээний мэргэжилтнүүд байгууллагаас тэдэнд мэдэгдсэн аюулгүй байдлын дүрмийг мөрдөнө; гэвч ИБ-ын үнэлгээний мэргэжилтэн ослоос сэргийлэх шаардлагатай бол тухайн газар эсвэл байгууллагыг нэн даруй орхих зэрэг яаралтай арга хэмжээ авна.

2.4.14. Хэрэв ББ-ын аудитын үнэлгээний аль ч үед ИБ-ын үнэлгээний мэргэжилтэн өндөр аюулын эрсдэл тулгарсан нөхцөлийг /эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин/ ажиглавал ИБ-ын үнэлгээний мэргэжилтэн ББ-ын аудитын багийн ахлагчтай яаралтай нууц хурал хийхийг хүсэх ба хуралд дээр гарч болзошгүй аюулын талаар мэдэгдэж, ББ-ын аудитын багийн ахлагч нь ББ-ын үйл явцын болон хуулиар тогтоомжийн дагуу энэ аюулын талаар тухайн байгууллагад мэдэгдэнэ.

**3. ҮЙЛ АЖИЛЛАГАА**

3.1. ИБ дараах зүйлсийг үнэлэх зохих шалгуур ба механизм байгаа эсэхийг шалгах бичмэл журамтай байна. Үүнд:

i) Хүсэлт гаргасан итгэмжлэлийн хамрах хүрээ (анхны эсвэл өргөтгөл) төлөөлөх байдлаар; болон
ii) Итгэмжлэлийн бүх мөчлөгийн явц дахь итгэмжлэлийн хүрээ.

3.2. Эдгээр журмууд нь энэхүү баримт бичгийн заалтуудтай тохирох ёстой бөгөөд дараах зүйлсийг нарийвчлан заана. Үүнд:

should occur after the audit, always in the absence of the CB’s client.

2.4.12. When relevant to the objective and scope of the witnessing, the AB's assessors shall get and review the CB's own audit report (and any additional information required).

2.4.13. It is the responsibility of the CB’s client to inform in advance the audit team and the AB assessors, of all the applicable safety requirements. AB assessors shall conform to safety rules made known to them by the organization; however, it is expected that AB assessors shall take immediate action at any time to avoid injury, including leaving the area or the organization if necessary.

2.4.14. If at any time during the assessment of a CB audit the AB assessor observes a potential condition he or she considers to be an imminent risk of high severity (e.g. health and safety or the environment) the AB assessor shall request an immediate private meeting with the CB’s audit team leader to inform him or her of the potential threat, with the expectation that the CB’s audit team leader will address the threat with the organization in accordance with the CB’s process and any legal obligation.

**3. PROCEDURES**

3.1. ABs shall have written procedures for ensuring that appropriate mechanisms and criteria are in place to cover and assess:

iii) the applicant scope of accreditation (initial or extension) in a representative way; and
iv) the scope of accreditation during each accreditation cycle.

3.2. Those procedures shall conform with the provisions set out in this document, and detail:

i) төлөөлөх түүвэр авах арга зам (тоон ба чанарын);
ii) итгэмжлэлийн хамрах хүрээнд хамрах механизм ба механизм бүрийг сонгох ба ашиглах шалгуур; болон
iii) хадгалах бүртгэл.

3.3. Гэрчлэх ажиллагааг тайлагнах үйл ажиллагаа нь энэ ажиллагааг гүйцэтгэхэд холбогдох шаардлага ба ББ үйл ажиллагаагаа явуулах ерөнхий чадвар, холбогдох шаардлагын хамт тухайн ББ-ын багийн гүйцэтгэл, тохирол, аудит явуулах үйл явцыг ББ хэрхэн хэрэгжүүлж буйг ИБ-ын үнэлгээний баг шүүж, дүгнэлт өгч нотолгоо гаргана.ИБ-ын гэрчлэх тайланд дараах зүйлс багтана. Үүнд:
i) ББ-ын төлөвлөгөөнд санал өгөх (аудитын хугацаа, аудитын хөтөлбөр хэрэв боломжтой бол аудитын төлөвлөгөөг тодорхойлох);
ii) аудитын баг (багийн ур чадвар, ажиллын томилгоо, хамрах үйл ажиллагааны хүрээ ба аудитын үр ашигтай байдал);
iii) аудитын техник (ярилцлага, үйл явц ба үйл ажиллагааны ажиглалт, баримтжуулалт ба бүртгэлд шалгалт хийх, түүвэр авах, аудитын мөшгөлтийг бий болгох, аудитын төрлийн шаардагдах элементүүдээс гарсан тохирол, үл тохирлыг батлах, бүртгэх, цуглуулах чадвар, цуглуулсан мэдээллийг зохимжтой зэрэглэх, өмнөх илрүүлсэн зүйлсийг боловсруулах, тайлагнах, нээлт, хаалтын хурал ба тайланг сонсох);
iv) Хэрэв боломжтой бол ББ-ын цуглуулсан мэдээлэл ба үйлчлүүлэгчийн МТ-ны тохирол, хэрэгжүүлэлттэй холбоотой дүгнэлт, ББ-ын аудитын багийн тайлагнаагүй эсвэл тодорхойлоогүй чухал мэдээлэлд санал өгөх;
v) бусад (жишээ нь:шударга байдал тогтсон эсэх, аюулгүй байдлын хэлэлцээр, нууцлал, засаглал болон хууль тогтоожийн мөрдөлт, гэрчлэх

i) the approach to achieve representative sampling (quantitatively and qualitatively);
ii) the mechanisms used to cover the scope of accreditation and the criteria for selection and use of each mechanism; and
iii) the records to be kept.

3.3. The procedures for reporting a witnessing shall give evidence and provide the conclusions and judgement of the AB assessment team as to the implementation of CB process to perform the audit and the conformity and performance of the CB team, with the relevant requirements and the overall competence of the CB for the activities it performs. AB witnessing report shall include where applicable:
i) comments on CB planning (determination of audit time, audit programme – if available - and audit plan);
ii) audit team (competence of the team, job assignment, scope coverage and effectiveness of the audit);
iii) auditing technique (interview, observation of processes and activities, review of documentation and records, sampling, establishment of audit trails, ability to collect, verify and record evidence of conformity and non-conformity in line with the required elements for the type of audit, appropriateness of grading of findings, handling of previous findings, reporting, opening and closing meetings and debriefs);
iv) comments on CB findings and conclusions in relation to the client MS conformity and implementation, and significant findings not reported or identified by the CB's audit team, if applicable;
v) others (e.g. whether impartiality was maintained, safety arrangements, confidentiality, regulatory or legal compliance, post-witnessing activities if included, conformity with the CB procedures);

ажиллагааны дараах үйл ажиллагаа, ББ-ын журмын мөрдөлт);

vi) Гэрчлэх аудитын явцад ИБ-ын илрүүлсэн зүйлс ба дүгнэлт; болон

vii) бодит аудитын илрүүсэн зүйлс ба дүгнэлтийг тусгасан ББ-ын тайлангийн найдвартай байдалд хийсэн дүгнэлт.

3.4. ИБ-ын гэрчлэх ажиллагааны тайлан нь ББ-ын гаргасан аудитын тайланг хуулбарлаагүй байвал зохино.

3.5. Хэрэв ИБ-ын үнэлгээний мэргэжилтэн ББ-ын аудитын туршид байгаагүй бол гэрчлэх тайланд гэрчлэх ажиллагаа явуулсан аудитын үйл ажиллагааг тусгана. (аудитын төлөвлөгөөний бүрдэл хэсгүүдийн тодорхойлолтыг болон ИБ МТ-ны стандартын аль шаардлагыг гэрчилснийг багтаасан байх).

## 4. ХҮРЭЭГ ТҮҮВЭРЛЭХ ОНЦЛОГ ХАНДЛАГА

### 4.1. Хэрхэн хүснэгтийг унших талаар - Тайлбарууд

4.1.1. IAF-ын бүх кодыг (IAF ID1-г үзнэ үү) МТ-ны баталгаажуулалтын төрөл бүр (ЧМТ, БОМТ болон ХЭМАБМТ)-д тохирох техникийн бүлгүүдэд нэгтгэсэн (холбогдох зохицуулалт, үйл явцын техникийн нарийн зүйлс, ББ-ын аудитын багийн үр дүнтэй ур чадвар зэргийг харгалзан үзнэ).

